# МОНГОЛ УЛС
# ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 23 өдөр Дугаар А/535 Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаал, 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 3 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нийт 2.4259 га (24259 $м^2$) газрыг хавсралтаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Р.Машбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ



6712011197

Аймгийн Засаг даргын 2023 оны
10 дугаар сарын…23. -ны өдрийн
А/535.дугээр захирамжийн хавсралт

## ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

| № | Эрх шилжүүлж байгаа иргэний овог, нэр, регистр | Эрх шилжүүлэн авч байгаа иргэний овог, нэр, регистр | Нэгж талбарын дугаар | Газрын зориулалт | Газрын байршил, хаяг | Газрын хэмжээ /м2/ | Газар эзэмшүүлэх хугацаа | Хүчингүй болгож буй захирамжийн дугаар | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Шуудай овгийн Төмөрхуяг Хадбаатар (РУ87041212) | Шагдар овгийн Пүрэвсүрэн Нуваантшарав (РП92111019) | 6712012418 | Гэр, орон сууцны хашааны газар | 7-р баг Их-Уул-4 420 тоот | 276 | 9 | Аймгийн Засаг даргын 2019.10.03-ны өдрийн А/422 дугаар захирамжийн хавсралтын 4 дэх заалт | Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр |
| 2 | Гацуууртан овгийн Чимэдцэрэн Ганбаатар (РС62021532) | Шарнууд овгийн Энэбиш Ичиннородов (РЭ84042601) | 6712008640 | Худалдаа нийтийн үйлчилгээний газар | 7-р баг ЗООНОЗ-ын урд талд | 85 | 21 | Аймгийн Засаг даргын 2019.10.31-ний өдрийн А/480 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх заалт | Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр |
| 3 | Бөөчүүд овгийн Чойдорж Оюунтуяа (ЦА83102503) | Бөөчүүд овгийн Чойдорж Оюунтуяа (ЦА83102503) | Шинээр | Жимс жимсгэнэ | 13-р баг Хаант | 13566 | 9 | Аймгийн Засаг даргын 2023.02.07-ны өдрийн А/52 дугаар захирамжийн хавсралтын 19 дэх заалт | Газар эзэмших эрх хэсэгчлэн шилжүүлэх гэрээгээр (6712017838) |
| 4 | | Өвөр тогоруутан овгийн Түмэндорж Пүрэвлов (РИ70050712) | Шинээр | Жимс жимсгэнэ | 13-р баг Хаант | 3980 | 9 | | |
| 5 | | Дарваан овгийн Өлзийсайхан Баттулга (БМ93071711) | Шинээр | Жимс жимсгэнэ | 13-р баг Хаант | 6352 | 9 | | |

Нийт газрын хэмжээ:24259м²

------------оОо-----------